Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд татварын тайлагнал, нягтлан бодох бүртгэлийг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 13-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Мэжик консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мөнхбаяр, аудитын менежер Н.Мөнхзаяа, туслах аудитор Ч.Алтангэрэл нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/35 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Монгол улс, ард иргэдийнхээ эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, төслийн өгөөжийг дээшлүүлэн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, удирдах эрхийг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчийн хувьд Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох
- Оюутолгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх;
- Төрд ногдох ашгийг төвлөрүүлэх. Үүнд:
  - Оюу Толгой ХХК-ийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого
  - Хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашгийг төвлөрүүлэх

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хувьцаа эзэмшигчийн хувьд гүйцэтгэх ажлын зорилтууд болон толгой компанитай хамтран ажиллах үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэх, Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн Монголын талын гишүүдэд дэмжлэг үзүүлэх зэрэг 4 ерөнхий зорилтын хүрээнд судалгаа шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль



- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрдэнэс Оюу Толгой ХХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 833.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн суурь үзүүлэлт нийт зардлын 1,730.3 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 17.3 сая төгрөгөөр тогтоолоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 385,642.7 сая төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                              | Эхний<br>үлдэгдэл  | Эцсийн<br>үлдэгдэл | /сая төгрөг/<br>Өөрчлөлт |
|-------------------------------------------------------|--------------------|--------------------|--------------------------|
|                                                       | 1                  | 2                  | 3=2-1                    |
| <b>Б</b>                                              |                    |                    |                          |
| Мөнгөн хөрөнгө                                        | 34.0               | 45.4               | 11.4                     |
| Авлага                                                | 1.2                | 6.3                | 5.1                      |
| Бараа материал                                        | 2.9                |                    | -2.9                     |
| Үндсэн хөрөнгө                                        | 82.4               | 68.0               | -14.4                    |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт                         | 2,304,003.5        | 2,689,647.0        | 385,643.5                |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                             | <b>2,304,124.0</b> | <b>2,689,766.7</b> | <b>385,642.7</b>         |
| Өр төлбөр                                             | 9,333.0            | 11,077.4           | 1,744.4                  |
| Төрийн өмч                                            | 300.0              | 300.0              | -                        |
| Эздийн өмч                                            | 2,294,491.0        | 2,678,389.3        | 383,898.3                |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө<br/>өмчийн дүн</b> | <b>2,304,124.0</b> | <b>2,689,766.7</b> | <b>385,642.7</b>         |



Өмнөх оны үзүүлэлтээс урт хугацаат хөрөнгө оруулалт, өр төлбөр, эздийн өмч данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Урт хугацаат хөрөнгө оруулалт 385,643.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Оюу Толгой ХХК-ийн гаргасан хувьцааны Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 34%-д ногдох өөрчлөлтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,744.4 сая төгрөгөөр өссөн нь толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн санхүүжилт 892.7 сая төгрөг, санхүүжилтийн хүүгийн өглөг 861.8 сая төгрөгөөр тус тус өсөж, татварын өр 10.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Өглөгийн данс 11,077.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь татварын өглөг 2.8 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК-д өгөх зээлийн өглөг 7,573.8 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 3,500.8 сая төгрөг байна.

Эздийн өмч 383,898.3 сая төгрөгөөр өссөн нь Оюу Толгой ХХК-ийн гаргасан хувьцааны Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 34%-д ногдох өөрчлөлт 385,643.5 сая төгрөгийн өсөлт, тайлан хугацааны үр дүн 1,730.3 сая төгрөгийн алдагдал, нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга 14.9 сая төгрөгийн бууралтаас шалтгаалжээ.

### 3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Хувьцаа эзэмшигчийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/06 дугаар тогтоолоор компанийн 2020 оны зардлын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдсан байна. Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн хооронд байгуулсан 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 0412017 тоот “Зээлийн гэрээ”-ээр охин компанийн 2017-2022 он хүртэлх үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг Эрдэнэс Монгол ХХК-аас зээл хэлбэрээр санхүүжүүлэхээр гэрээнд тусгасан байна.

Тайлант оны зардлын төсөв 1,423.3 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр Эрдэнэс Монгол ХХК-аас 841.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 581.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Гүйцэтгэлээр нийт зардал 841.5 сая төгрөг болж, батлагдсан төсвөөс 40.9 хувь буюу 581.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан нь ковид-19 цар тахлын улмаас зарим ажлууд хойшлогдсон шалтгаанаар цалин, НДШ-ийн зардал 139.1 сая төгрөг, томилолтын зардал 135.3 сая төгрөг, хууль зүйн мэргэжлийн туслалцааны зардал, ажилтны нийгмийн хамгааллын зардал 250.8 сая төгрөг, бусад урсгал зардлууд 56.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үндсэн үзүүлэлт, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн дүрэмд заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс 154 мэдээллийг хугацаанд нь, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.



### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |      | Биелэлт |      | /сая.төгрөг/<br>Гүйцэтгэлийн хувь |
|-----------------|---------------------|------|---------|------|-----------------------------------|
|                 | Тоо                 | Дүн  | Тоо     | Дүн  |                                   |
| Акт             | 1                   | 1.1  | 1       | 1.1  | 100                               |
| Албан шаардлага | 1                   | 9.9  | 1       | 9.9  | 100                               |
| Зөвлөмж         | 2                   | -    | 2       | -    | 100                               |
| Нийт дүн        | 4                   | 11.0 | 4       | 11.0 | 100                               |

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 61.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 30.3 сая төгрөгийн алдааг залруулж, 31.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах 0.1 сая төгрөг, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өмнөх тайлант хугацааны ХХОАТ-ын өр 13.3 сая төгрөгийг залруулахдаа тайлант хугацааны цалингийн зардлаар бүртгэж буруу тайлагнасан;
2. Тавилга эд хогшил дансанд 6.1 сая төгрөгийн компьютер болон каноныг ангилал буруу бүртгэж тайлагнасан;
3. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 10.9 сая төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Тайлант онд байгууллагын нэр бүхий 12 ажилтанд 31.1 сая төгрөгийн шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. Шилэн дансны нэгдсэн цахим системд 19 мэдээллийг хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Аудитаар илэрсэн 3 зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.



#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Татварын тайлагналтай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

ХХОАТ-ын тайланг Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/48 тоот тушаалаар батлагдсан маягаар гаргаагүй буюу санхүүгийн программд шинэчлэл хийгээгүй байна. ХХОАТ-ын хөнгөлөлтийн тохиргоог хийгээгүйн улмаас 6 ажилтанд 0.09 сая төгрөгөөр илүү, 2 ажилтанд 0.03 сая төгрөг, нийт 0.1 сая төгрөгөөр дутуу хөнгөлөлт эдлүүлсэн байна. Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/48 дүгээр тушаалын 1-р хавсралт "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2. Эрсдэл:

ХХОАТ илүү эсвэл дутуу суутгагдах, ирээдүйд татварын акт торгууль хүлээх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

###### 1.3. Өгсөн зөвлөмж

Санхүүгийн программын шинэчлэлийг тухай бүр хийж, санхүү татварын тайланг үнэн зөв гаргаж байх;

###### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

##### 2. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

###### 2.1. Илрүүлэлт:

Тээврийн хэрэгсэл, компьютер, бусад дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшлын дансанд хэсэгчилсэн гэнэтийн тооллого хийхэд үндсэн хөрөнгийг кодлоогүй зөрчил илэрч байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 2.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт тавих хяналт хангагдахгүй байх, хөрөнгө үрэгдэх, хууль, заавар журам зөрчигдөх;

###### 2.3. Өгсөн зөвлөмж



Үндсэн хөрөнгийг иж бүрэн кодолж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тухай бүр нь бүртгэж тайлагнаж байх;

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

**3. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Худалдан авалтыг цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад тайлант хугацаанд ногдох цахим и-баримт 2021 онд шивэгдсэн зөрчил илэрч байна. Мөн баримтыг урьдчилан дугаарладаггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", мөн Сангийн сайдын 2017 оны 12 сарын 5-ны 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын нэгдүгээр зүйлд "...Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана." гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, хэмжилт, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Эрсдэл:**

Хууль, тогтоомж заавар, журам зөрчигдөх, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан байх;

**3.3 Өгсөн зөвлөмж:**

Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтын системтэй тулган хянаж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах;

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

|                                                               |                                                                                                      |                                             |
|---------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------|
| Огноо:<br><b>2020 он</b>                                      | Аудитын нэр:<br><b>Эрдэнэс Оюу Толгой ХХК 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b> | Аудитын код:<br><b>САГ-2021/77/СТА-ТӨҮГ</b> |
| Шалгагдсан байгууллагын нэр:<br><b>Эрдэнэс Оюу Толгой ХХК</b> | Сая төгрөг                                                                                           |                                             |

| №   | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                          |
|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------------------|---------------------------------------------------|--------------------------|
|     |                                                                                                                                                                                                                                                                                                                                          |            | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр                 |
|     | 1                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 2          | 3                                     | 4                                                 | 5                        |
| 1   | Тайлант онд байгууллагын нэр бүхий 12 ажилтанд 31.1 сая төгрөгийн шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон байна.                                                                                                                                                                                                                       | 31.1       | Албан шаардлага                       | Гүйцэтгэх захирал<br>Ерөнхий нягтлан              | Ц.Түмэнцогт<br>Г.Мөнхтөр |
| 2   | ХХОАТ-ын тайланг Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/48 тоот тушаалаар батлагдсан маягтаар гаргаагүй буюу санхүүгийн программд шинэчлэл хийгээгүй байна. ХХОАТ-ын хөнгөлөлтийн тохиргоог хийгээгүйн улмаас 6 ажилтанд 0.09 сая төгрөгөөр илүү, 2 ажилтанд 0.03 сая төгрөг, нийт 0.1 сая төгрөгөөр дутуу хөнгөлөлт эдлүүлсэн байна. | 0.1        | Зөвлөмж хүргүүлэх                     | Захирал<br>Ерөнхий нягтлан                        | Ц.Түмэнцогт<br>Г.Мөнхтөр |
| 3   | Тээврийн хэрэгсэл, компьютер, бусад дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшлын дансанд хэсэгчилсэн гэнэтийн тооллого хийхэд үндсэн хөрөнгийг кодлоогүй зөрчил илэрч байна.                                                                                                                                                                    |            | Зөвлөмж хүргүүлэх                     | Захирал<br>Ерөнхий нягтлан                        | Ц.Түмэнцогт<br>Г.Мөнхтөр |
| 4   | Худалдан авалтыг цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад тайлант хугацаанд ногдох цахим и-баримт 2021 онд шивэгдсэн зөрчил илэрч байна. Мөн баримтыг урьдчилан дугаарладаггүй байна.                                                                                                                                          |            | Зөвлөмж хүргүүлэх                     | Захирал<br>Ерөнхий нягтлан                        | Ц.Түмэнцогт<br>Г.Мөнхтөр |
| 5   | Шилэн дансны нэгдсэн цахим системд 19 мэдээллийг хоцроож байршуулсан байна.                                                                                                                                                                                                                                                              |            | Албан шаардлага                       | Захирал<br>Ерөнхий нягтлан                        | Ц.Түмэнцогт<br>Г.Мөнхтөр |
| ДҮН |                                                                                                                                                                                                                                                                                                                                          | 31.2       |                                       |                                                   |                          |





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 317/СОН0085

Улаанбаатар хот

С.ӨӨ- 0001/77/СТА- 704Г

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын нэр бүхий 12 ажилтанд 31,067,000.00 /гучин нэгэн сая жаран долоон мянган/ төгрөгийн шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаж, холбогдох хууль журамд заасны дагуу шагнал, урамшууллыг олгож байх, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн захирал Ц.Түмэнцогт, ерөнхий нягтлан бодогч Г.Мөнхтөр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*В. Н. Н.*

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

*М. Лхагвасүрэн*

М.ЛХАГВАСҮРЭН

С.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherem\Yawsan\_Bichig\2021\0315\auditin 2-R Газар125.Docx

001080448





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 318/СОН 0085

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 173 мэдээлэл байршуулахаас 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн захирал Ц.Түмэнцогт, ерөнхий нягтлан бодогч Г.Мөнхтөр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ЛХАГВАСҮРЭН

С.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

V:\10.10.20\Bichig\_Khureg\Alban Shaardlaga\2021\0315audit\10 2-R Газар\126.Docx

